МОНГОЛ УЛС
# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/23 Мандалговь

Дэд зөвлөл шинэчилэн
байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг" -ийн 11.2 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх дэд зөвлөл" –ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга: | - Аймгийн Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | - Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| Гишүүд: | - Татварын хэлтсийн дарга |
| | - "Тэвшийн говь" ХХК-ний захирал |
| | - "Гурвансайхан" ХХК-ний захирал |
| | - "Төгс аялгуут" ТББ-ийн тэргүүн |
| | - "Ажил олгогч эздийн холбооны Дундговь дахь салбарын дарга |

Хоёр. Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд орон нутагт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, хяналт тавих арга хэмжээг зохион байгуулан ажиллахыг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Дэд зөвлөл байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2013 оны А/907 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

D:\2017 Ochirbat doc\Barimt bichig P.Ochirbat-2018\Zaxiramg.doc

0200089